



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 78

Мөрөн

Мал хамгаалах сангийн журам батлах тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.2, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 374 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мал хамгаалах сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хадгалах хамгаалах, тайлагнах журмыг хавсралтаар баталсугай.

2. Мал аж ахуйн салбарын байгалийн эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлэх зорилгоор мал хамгаалах сангийн хөрөнгийг журмын дагуу бүрдүүлэн, хуулийн хүрээнд зарцуулан ажиллахыг аймгийн Засаг дарга /Л.Ганболд/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Цогтоо/-д даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР



МАЛ ХАМГААЛАХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журам нь Хөвсгөл аймгийн “Мал хамгаалах” сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

“Засгийн газрын тусгай сангийн тухай” хууль, “Төсвийн тухай” хууль, “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай” хууль болон Монгол улсын Засгийн газрын 2011 оны 374 дүгээр тогтоол, 2010 оны 197 дугаар тогтоол, Засгийн газар, аймгийн ЗДТГ-аас хэрэгжүүлж буй Мал аж ахуйн салбарын бодлого, хөтөлбөрт нийцүүлэхийг зорьж боловсруулсан болно.

1.2 “Мал хамгаалах сан” нь “Төсвийн тухай” хуулийн 4.1.50 заалтад заасны дагуу нэгээс дээш төсвийн жил дамжин хэрэгжих ба өөрийн эх үүсвэрийг хуульд заасан үйл ажиллагаанд зарцуулж, түүнээс олох орлого, эсхүл зарцуулсан хөрөнгийн эргэн төлөлтийг тухайн үйл ажиллагааг дахин санхүүжүүлэх зориулалттай “Эргэлтийн сан”-гийн хэлбэрээр зохион байгуулагдах орон нутгийн тусгай сангийн төрөлд хамаарна.

1.3 “Төсвийн тухай” хуулийн 18.5 дахь заалтын дагуу “Мал хамгаалах сан” нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

1.4 Журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан өдрөөс эхлэн мөрдөнө.

Хоёр. Мал хамгаалах сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1 Аймгийн ХХАА-н газрын дарга нь аймгийн Засаг дарга болон Аймгийн онцгой комиссын шийдвэрээр өгсөн үүрэг чиглэлийн дагуу сангийн өдөр тутмын үйл ажиллагааг аймгийн ИТХурлаас баталсан төсвийн хүрээнд удирдлагаар хангаж ажиллана.

2.2 Сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлж байна.

2.2.1 “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн 23 дугаар зүйл, “Төсвийн тухай” хуулийн 58.2.8, 58.2.9 заалтад заасан арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.2.2 Засгийн газрын 2010 оны 197 дугаар тогтоолын 25 дугаар заалтын дагуу малжуулах төслийн эргэн төлөлтийг зохион байгуулан, санд төвлөрүүлэх, төвлөрсөн орлогыг хууль, журмын дагуу зарцуулах;

2.2.3 Аймгийн өвс тэжээлийн нөөцөд чанарын шаардлага хангасан өвс, тэжээлийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуульд нийцүүлэн бэлтгэх, шаардлагатай тохиолдолд бүсийн сумдын фондод татан төвлөрүүлж байршуулах

